

Төсөл

Санхүүгийн зохицуулах хорооны
20.. оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ДААТГАГЧИЙН БАТАЛГАА ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь даатгагч Даатгалын тухай хуулийн 4.1.13-т заасан даатгагчийн баталгаа гаргахад тавигдах шаардлагыг тогтоох, түүнд хяналт тавих, Иргэний хуулийн 234, 457 дугаар зүйлүүдэд заасан зарим харилцааг зохицуулахад оршино.

1.2 Даатгагчийн баталгаа нь Даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан даатгалын ангилал, төрөл, хэлбэрт хамаарахгүй бөгөөд Даатгалын багц дүрмийн 16 дугаар хавсралт “Даатгалтай холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар”-т заасан даатгагчийн эрхлэх үйл ажиллагаанд хамаарна.

1.3 Даатгагчийн гаргах баталгаанд дараах оролцогчид оролцоно. Үүнд:

1.3.1. Баталгаа гаргагч буюу Даатгалын тухай хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагч;

1.3.2. Үүрэг гүйцэтгүүлэгч буюу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан этгээд;

1.3.3. Үүрэг гүйцэтгэгч буюу баталгааны гэрээний дагуу даатгагчийн хүлээсэн үүрэг, гүйцэтгэсэн төлбөрийг тодорхой хугацааны дараа даатгагчид буцаан төлж барагдуулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн;

1.3.4. Давхар даатгагч буюу даатгагчийн гаргах баталгааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 4.1.9-д заасан давхар даатгалын компани.

1.4 Даатгагч нь дараах төрлийн баталгааг гаргаж болно. Үүнд:

1.4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.7-д заасан тендерийн баталгаа;

1.4.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.8-д заасан урьдчилгаа төлбөрийн баталгаа;

1.4.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ыажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.17-д заасан гүйцэтгэлийн баталгаа;

1.4.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасан чанарын баталгаа;

1.4.5. Даатгалын тухай хуулийн 6¹.1.1-д заасан орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн баталгаа.

1.4.6. Хорооноос зөвшөөрсөн бусад.

Хоёр. Даатгагч баталгаа гаргахад тавигдах шаардлага

2.1 Даатгагч баталгаа гаргах тохиолдолд энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан мэдэгдлийн маягтын дагуу мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нд ирүүлэх бөгөөд мэдэгдэлд дараах материалыг хавсаргана. Үүнд:

2.1.1 Баталгаа гаргахаар шийдвэрлэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн шийдвэрийн хуулбар;

2.1.2 Даатгагч баталгаа гаргахтай холбоотой ТУЗ-аар батлуулсан тусгайлсан журам. Тус журамд дор хаяж дараах зүйлсийг тусгасан байна:

2.1.2.1 Даатгагчийн гаргах баталгаатай холбогдох эрсдэл, эрсдэлийг удирдах журам, аргачлал, эрсдэлийн удирдлагын үйл явц;

2.1.2.2 Үүрэг гүйцэтгэгчийг хэрхэн таньж мэдэх, эрсдэлийн үнэлгээг хэрхэн хэрэгжүүлэх, хүлээсэн үүргээ биелүүлэх чадвартай эсэх, гэрээний шаардлагад нийцсэн туршлага, ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, гүйцэтгэх санхүүгийн чадавхтай эсэхийг шалгаж, нягтлах аргачлал;

2.1.2.3 Даатгагч санхүү, төлбөрийн чадварын байдалдаа тохирсон даатгагчийн баталгаагаар өөрийн хүлээж болох нийт болон нэгж эрсдэлийн дээд хэмжээ, түүнийг тогтоох аргачлал;

2.1.2.4 Даатгагчийн баталгааны хураамжийн хувь хэмжээг тооцох аргачлал, түүнд ашиглах шалгуур үзүүлэлтийн талаар;

2.1.2.5 Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааг давхар даатгуулах бодлого, стратеги;

2.1.2.6 Даатгагчийн баталгаа гаргахыг шийдвэрлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, хариуцах нэгж, түүний бүтэц;

2.1.2.7 Даатгагчийн баталгаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, түүнд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар;

2.1.2.8 Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаа, хяналт болон даатгагчийн баталгааны тусгайлсан журмын хэрэгжилтийн талаар ТУЗ-д цаг тухайд нь, үнэн зөв, хараат бус, бодит байдлаар тайлагнах талаар.

2.2 Энэ журмын 2.1.2.3-т заасан даатгагчийн өөрийн хүлээж болох нийт болон нэгж эрсдэлийн дээд хэмжээг тооцохдоо Хорооны 2022 оны 558 дугаар тогтоолоор баталсан “Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцааны журам”-ын тооцоолол, аргачлалыг харгалзан үзсэн байна.

2.3 Даатгагч баталгаа гаргах бодлого, төлөвлөгөө боловсруулан тухайн жилийн давхар даатгалын стратеги төлөвлөгөөнд тусгасан байна.

2.4 Даатгагчийн баталгаагаар өөрийн хүлээж болох нийт болон нэгж эрсдэлийн дээд хэмжээг даатгагчийн ТУЗ нь улирал бүр тогтоох бөгөөд ТУЗ-ийн шийдвэрийг тухай бүр давхар даатгагчид хүргүүлнэ.

2.5 Даатгагч баталгаа гаргах тухай бүрт дараах шаардлагыг хангасан эсэхийг нягталсан байна. Үүнд:

2.5.1 Даатгалын багц дүрмийн 2 дугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-д заасан даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 120 ба түүнээс дээш хувь байх;

2.5.2 Даатгагчийн баталгааг гэрээ тус бүрээр гаргах ба баталгааны хязгаар нь дараах хязгаартай байна:

2.5.2.1 Энэ журмын 1.4.1-1.4.4-т заасан баталгааны хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан;

2.5.2.2 Энэ журмын 1.4.5, 1.4.6-д заасан баталгааны хувьд тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт үнийн дүнгийн 15 хувиас хэтрэхгүй бөгөөд хожим байгуулах нэмэлт барааны нийлүүлэлт, хугацаа сунгасан болон өргөтгөсөн ажил, үйлчилгээтэй холбогдох гэрээний харилцаанд тухайн хувийг баримтална.

2.5.3 Даатгагчийн баталгааны гэрээг тодорхой төсөл, хөтөлбөрт буюу төрийн худалдан авах цахим системд байршуулсан захиалга, төсөлд байгуулна.

Гурав. Даатгагч баталгаа гаргах

3.1 Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалт, удирдлагыг давхар даатгагчийн дэргэд байгуулсан баталгааны гэрээ байгуулах даатгагчдын төлөөллөөс бүрдсэн Даатгагчийн баталгааны эрсдэлийн удирдлагын хороо (цаашид “Эрсдэлийн хороо” гэх) хариуцах бөгөөд тус Эрсдэлийн хороо нь дараах үүргийг хүлээнэ:

3.1.1 энэ журмын 1.4.1-д заасан тендерийн баталгааны гэрээний загварыг гаргах;

3.1.2 даатгагчийн баталгааны үнэлгээ, хураамжийн хувь, хэмжээг тогтоох аргачлалыг боловсруулах;

3.1.3 энэ журмын 1.4.1-д зааснаас бусад баталгааг гаргахад тавигдах шаардлагыг тодорхойлох;

3.1.4 даатгагчийн баталгаа гаргах боломжит хөрөнгийн хэмжээтэй уялдуулан баталгааны гэрээний нөхөн төлбөр олгох тухай журмыг боловсруулах;

3.1.5 Давхар даатгагчийн даатгах хэсгийг тодорхойлох.

3.2 Даатгагч баталгаа гаргахдаа энэ журмын 2.1.2-т заасан даатгагчийн баталгааны тусгайлсан журмын дагуу гаргах бөгөөд дараах зарчмыг баримтална:

3.2.1 энэ журмын 1.4.1-д заасан тендерийн баталгаа гаргах эсэхийг энэ журмын 2.1.2.6-д заасан хариуцах нэгж тухай бүр шийдвэрлэнэ;

3.2.2 энэ журмын 1.4.1-д зааснаас бусад баталгааг гаргах тохиолдолд энэ журмын 3.1-д заасан Эрсдэлийн хороонд холбогдох материалыг ирүүлэх бөгөөд уг хороо нь тухайн баталгааг гаргах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.3 Баталгаа гаргасан даатгагч дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.3.1 Даатгалын баталгаа гаргуулах бүтээгдэхүүн үйлчилгээний төлбөр нэг удаа бүрэн төлөгдөх хэлбэртэй байна;

3.3.2 Баталгаа гаргах бүрт баталгааны гэрээний дуусах хүртэлх хугацаанд гэрээний дүнгээр эрсдэлийн санг байгуулж, даатгагчийн Учирч болзошгүй хохирлын нөөц санг нэмэгдүүлнэ;

3.3.3 Даатгагч баталгааны төлбөрийг үүрэг гүйцэтгүүлэгчийн анхны шаардлагаар буюу мөнгөн төлбөрийн нэхэмжлэлийг үндэслэн баталгааны гэрээнд заасан нөхцөлөөр олгоно.

3.4 Үүрэг гүйцэтгүүлэгч нь даатгагч энэ журмын 2.1.2.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах бөгөөд үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангана.

3.5 Үүрэг гүйцэтгэгчийн хууль бус шийдвэр, үйлдлээс үүдэн даатгагч нь үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахаар бол үүрэг гүйцэтгэгчээс буцаан нэхэмжлэх үндэслэлийг баталгааны гэрээнд тусгасан байна.

Дөрөв. Даатгагчийн баталгааны бүртгэл, тайлан

4.1 Даатгагч хийгдсэн баталгааны гэрээний бүртгэлийг гэрээ, огноогоор тухай бүр хөтөлж, нэгдсэн бүртгэлийг сар бүр давхар даатгагчид дараа сарын 5-ны өдрийн дотор илгээнэ.

4.2 Давхар даатгагч даатгалын компаниудын хийсэн даатгагчийн баталгааны бүртгэлийг хөтөлж, энэ журмын 1.4-т заасан баталгааны төрөл тус бүрийн хувьд нэгдсэн бүртгэлийг Хороонд дараа сарын 10-ны өдрийн дотор энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу ирүүлнэ.

4.3 Даатгагч нь гаргасан баталгааны тайланг энэ журмын гуравдугаар хавсралтаар баталсан маягтын дагуу улирал бүрийн санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

Тав. Хяналт, хариуцлага

5.1 Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Эрсдэлийн хороо энэ журамд заасан холбогдох асуудлын хүрээнд хяналт тавьж ажиллана.

5.2 Даатгагчийн баталгаатай холбоотой гэрээ, үйл ажиллагаатай холбоотой аливаа маргааныг Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

5.3 Хороо энэ журмын хэрэгжилтэд байнга хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--oOo--

*“Даатгагчийн баталгаа гаргах үйл
ажиллагааны журам”-ын хоёрдугаар хавсралт*

Даатгагчийн баталгааны талаарх мэдээлэл

Хугацаа: ... дугаар сар

№	Даатгагчийн нэр	 баталгааны гэрээ		
	Үүрэг гүйцэтгүүлэгч	Үүрэг гүйцэтгэгч	Дүн	Хураамж	Төлбөр
1	“..... даатгал” ХК/ХХК				
1.1			
1.2					
1.3					
2	“..... даатгал” ХК/ХХК				
2.1					
2.2					
2.3					
	Нийт				

ТАЙЛАН ГАРГАСАН:

Овог, нэр

албан тушаал

гарын үсэг

огноо

Тамга

*“Даатгагчийн баталгаа гаргах үйл
ажиллагааны журам”-ын гуравдугаар хавсралт*

“..... даатгал” ХХК-ийн баталгаа гаргах

үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл

... оны ... дүгээр сарын ... өдөр
/төгрөгөөр/

№	Баталгааны төрөл	Гэрээний тоо	Гэрээний нийт дүн	Хураамжийн дүн	Гэрээний төлбөр төлсөн тоо	Гэрээний төлбөрийн дүн	Давхар даатгалын хураамж
1	Тендерийн баталгаа						
2	Урьдчилгаа төлбөрийн баталгаа						
3	Гүйцэтгэлийн баталгаа						
4	Чанарын баталгаа						
5	Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн баталгаа						
6	Бусад /нэрлэх/						
	Нийт						

ТАЙЛАН ГАРГАСАН:

Овог, нэр

албан тушаал

гарын үсэг

огноо

Тамга